



## МАХИМПЭКС ХК

18104 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,  
4 дүгээр хороо, Их наран, Өөрийн байр-1  
Утас: 70172471, Факс: (976) 70002517  
И-мэйл: makhimrex1946@makhimrex.mn,  
<http://www.makhimrex.com>

2020 04 01 № 150  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


Хүсэлт гаргах тухай

Манай компани Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг энэ оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цагт хийхээр төлөвлөж холбогдох шийдвэрийг танай байгууллагад хүргүүлсэн билээ.

Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаа цахимаар санал хураах ажиллагааг зохион байгуулахаар болсон тул Хөрөнгийн биржийн сайтад байршуулсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард өөрчлөлт оруулж өгч бидний ажилд туслана уу.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг шинэчлэн хүргүүлэв. /Хавсралт -1 хуудас/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БҮДРАГЧАА

## **“ МАХИМПЭКС ” ХК- ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Онцгой нөхцөл байдал үүссэн тул “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниуд нь хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор зарлан хуралдуулах боломжгүй болоод байна.

Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаа цахимаар санал хураах арга хэмжээ зохион байгуулж байгааг Та бүхэн ойлгож дэмжинэ гэдэгт компанийн удирдлага итгэж байна.

“Махимпэкс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдээс ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар цахим болон шуудангаар санал хураах ажиллагааг 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 4 дүгээр сарын 24-ний өдрийн 13 цаг хүртэл зохион байгуулах болсныг мэдэгдэж байна.

### **ШИЙДВЭР ГАРГАХ АСУУДЛУУД :**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2020 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах

Та бүхэн Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 4-р хороо, Хүнсчдийн гудамж Махимпэкс ХК-ийн байранд 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 4 дүгээр сарын 24-ний өдрийн 13 цаг хүртэл өглөө 10.00-16.00 цагийн хооронд ирж, шийдвэр гаргахтай холбогдох материалтай танилцаж саналын хуудсаа бөглөх, эсвэл компанийн [www.makhimpex.mn](http://www.makhimpex.mn) цахим хаягаар саналтай танилцаж саналын хуудсаа ирүүлэх замаар саналаа өгөх боломжтой.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

УТАС: 98555575, 98656598